



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 09 өдөр


Дугаар 54

Арвайхээр

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Орон нутагт хоршоог хөгжүүлэх нөхцөл боломжийг бий болгож, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА  А.ИШДОРЖ



“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал

Хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршиж, хамтарч үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нь бүтээмжийг өсгөж, баялаг бүтээж, ажлын байр нэмэгдүүлэх зэргээр нийгэм эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төр засгаас хоршооллыг олон улсын түгээмэл зарчимд нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөтөлбөр гаргаж дэмжлэг үзүүлэх, олон улсын байгууллагын зээл тусламж, төсөл хөтөлбөрүүдийг хоршоодод чиглүүлэх бодлогоор дэмжиж ажиллаж ирсэн.

МУ-ын Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоолоор хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-II”-ийг 2010-2017 онуудад хэрэгжүүлэхээр баталсан.

2017 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 5900 орчим гишүүн бүхий анхан шатны 182 хоршоо, хадгаламж зээлийн 7 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Хоршоодыг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл 40% нь газар тариалан, мал аж ахуй хосолсон, 25% нь бөөний болон жижиглэн худалдаа, 25% нь түүхий эд бэлтгэл, 10% нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр тус тус ажиллаж байна.

Мөн аймгийн хэмжээнд “Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо”, “Эд хэрэглэгчдийн хоршоодын холбоо”, “Үйлдвэр үйлчилгээний хоршоодын холбоо” гэсэн 3 мэргэжлийн холбоо, 1 сургалт мэдээллийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна хоршоог хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд хариуцан ажиллаж байна.

Хоршоог хөгжүүлэх талаар төрийн бодлогын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч дараах асуудлууд тулгамдсан хэвээр байна. Үүнд:

Гадны хүчин зүйлс

- Байгаль цаг уур / ган зуд /
- Зан заншил, уламжлалт сэтгэлгээ
- Зах зээлийн хөгжил муу
- Төрийн дэмжлэг, хүртээмж сул
- Санхүүгийн үйлчилгээ авах боломж бага /банкнаас тавих шаардлага өндөр, барьцаа хөрөнгө бага, гишүүд давхар зээлтэй байх/
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх тогтолцоо бүрдэж байгаа ч хангалтгүй
- Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг, нүүдлийн иргэншилтэй
- Хоршооны чиглэлээр ажилладаг холбоод, ТББ, хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо муу

Хоршооноос хамааралтай бэрхшээл

- Гишүүдийн жигд оролцоо сул
- Харилцан итгэлцлэл байхгүй
- Санхүүгийн хувьд бэхжээгүй
- Хоршоодын удирдлагын манлайлах чадвар сул
- Менежмент сул
- Гишүүдийн байршил алслагдсан, байнгын нүүдэл суудал нь хамтарч ажиллахад хүндрэл учруулдаг
- Зах зээлийн нийгэмд зохицож амьдрах туршлага, мэдлэг чадвар сул, чадвар туршлагатай боловсон хүчин дутагдалтай
- Мэдээлэл, үйлдвэрлэлийн шинэ технологийн мэдлэг дутмаг
- Банк, санхүүгийн байгууллагатай харьцах мэдлэг дутмаг
- Хоршоо нь хувь нийлүүлж хоршоо болох, хуримтлал бий болгох гэдэг ойлголтыг бодит амьдралд хэрэгжүүлдэггүй

2. Үндэслэл, хэрэгцээ шаардлага:

Аймгийн статистикийн мэдээнд үйл ажиллагаа явуулж байгаа хоршооны тоо л байна. Хоршоод өнөөдөр хэдэн ажлын байр бий болгосон, хэдий хэмжээний үйлдвэрлэл, борлуулалт хийдэг, ДНБ-д ямар хувь эзэлдгийг бодитоор илэрхийлэх мэдээлэл, судалгаа байхгүй байна.

Хоршоог дэмжих чиглэлээр төр засгаас олон төрлийн шат дараалалтай хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлсээр байгаа боловч одоогийн байдлаар бие даасан санхүүгийн хувьд тогтворжсон амжилттай ажиллаж байгаа хоршоодын тоо цөөн байсаар байна.

Засгийн газраас мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ үндэсний үйлдвэрт тушаасан малчдад олгох урамшуулалыг зөвхөн хоршооны гишүүдэд олгохоор шийдвэр гаргасны улмаас сүүлийн жилүүдэд орон нутагт чөнжийн буюу эзний хоршоод олноор бий болж, сайн дурын үндсэн дээр хувь нийлүүлэн, хоршоо байгуулж, хуримтлал үүсгэн, зарчмын дагуу ажиллаж байгаа хоршоо цөөхөн байна.

Хоршоодын гишүүдийн тоог сайн дурын үндсэн дээр нэмэгдүүлэх, хоршоодын менежментийг сайжруулах, дундын хоршоодыг бий болгож, кластераар хөгжүүлэх эхлэлийг тавих зэрэг хоршоог олон улсын хоршооллын зарчимд нийцүүлэн сонгодог утгаар нь хөгжүүлэх асуудал нэн чухал болж байна.

Иймд орон нутгийн түвшинд хоршоодын хөгжлийг түргэсгэх, чадавхижуулахын тулд "Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хоршоолол хөгжих нийгэм эдийн засгийн таатай орчин бүрдэж, хоршооны гишүүдийн орлого, амьжиргааны түвшин дээшилнэ. Мөн Хоршооны хөгжлийг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжсэнээр хоршоод болон гишүүдийн тоо өсч, хоршоодын салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ борлуулалт нэмэгдэж дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ өснө гэж үзэж байна.

Хоёр. Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим

Энэхүү хөтөлбөрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хоршооллын дараах зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

- 2.1. Сайн дурын болон нээлттэй гишүүнчлэл бүхий байх
- 2.2. Гишүүдийн ардчилсан хяналт, удирдлагатай байх
- 2.3. Гишүүдийн эдийн засгийн оролцоог хангасан байх
- 2.4. Бүрэн эрхт бие даасан байдалтай байх
- 2.5. Боловсрол, сургалт мэдээлэл бүхий байх
- 2.6. Хоршоо хоорондын хамтын ажиллагааг хангасан байх
- 2.7. Нийгмийн хөгжлийн төлөө байх

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Хоршоо, нөхөрлөлийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хоршооны гишүүдийн орлого, чадамжийг дээшлүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ.

4.1. Хоршоо, нөхөрлөлийн хөгжлийг бодлогоор дэмжих таатай орчинг бүрдүүлэх

4.2. Хоршоодын санхүүгийн эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлж, кластераар хөгжүүлэх

4.3. Хоршоодыг чадавхижуулах, инноваци нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах

4.4. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах нэгдсэн сүлжээ, үйлчилгээг бий болгох, зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Хоршооны хөгжлийг бодлогоор дэмжих таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1. Аймгийн стратегийн шинж чанар бүхий бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа хоршооны хөгжлийн асуудлыг тусгаж байх.

5.1.2. Аймгийн хэмжээнд хоршоог үнэлэх ажлыг зохион байгуулж, жишиг хоршоог шалгаруулах

5.1.3. Хоршоодын төлөөлөлийг дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаа, уулзалт зөвлөгөөн, амжилттай ажиллаж байгаа хоршоодын туршлага судлах гэх мэт үйл ажиллагаанд оролцоход хөрөнгө санхүүгийн бодлогоор дэмжих.

5.1.4. Аймгийн тэргүүний хоршоо шалгаруулах журмыг боловсруулан батлуулж, шилдэг хоршоодыг жил бүр урамшуулах.

5.1.5. Төсвийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авалтанд орон нутгийн хоршоодыг нийлүүлэгчээр оролцуулах боломжийг бүрдүүлэх.

5.1.6. Хөдөө аж ахуйн хоршоодод үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад нь шаардагдах бэлчээр, газар, тариалангийн талбай, түүний орчмын нутгийг гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах

5.2. Хоршоодын санхүүгийн эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлж, кластераар хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.1. Хоршоо, нөхөрлөлийг аймгийн ЖДҮХСан болон СХСангийн хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих

5.2.2. Барьцаа хөрөнгө нь хүрэхгүй байгаа хоршоодыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, энэ талын мэдлэг мэдээллээр хангах.

5.2.3. Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа малчид, тариаланчдад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зэргийг худалдан авахад нь зориулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл /хөтөлбөрт/-д бодлогоор хамруулах ажлыг зохион байгуулах.

5.2.4. Донор байгууллагуудын хөрөнгө оруулалтыг хоршооллын салбарт чиглүүлж, зээл, тусламж, санхүүгийн түрээс зэрэг хөрөнгө оруулалтаар зуучлан дэмжих

5.2.5. Хоршооллын салбарт кластер байгуулах санал санаачлага, кластерт нэгдэх үйл ажиллагааг дэмжих, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох

5.3. Хоршоог чадавхижуулах, инноваци нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.3.1. Хөрөнгө, хөдөлмөрөө хоршин амжилттай ажиллаж байгаа тэргүүний хоршооны үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах, шагнал урамшуулалд тодорхойлох арга хэмжээг зохион байгуулах.

5.3.2. Залуу үеийг ХАА-н салбарт, тэр дундаа хоршооллын хөдөлгөөнд сайн дураараа нэгдэх үйл явцыг дэмжих, боловсон хүчний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, мэргэшүүлэх

5.3.3. Хоршооллын салбарт инновацийг нэвтрүүлэхийг дэмжих, урамшуулах замаар өрсөлдөх чадварыг өсгөх

5.3.4. Хоршоодыг сүүлийн үеийн техник технологийн мэдээ мэдээллээр хангах

5.3.5. Хоршоодын удирдлага, менжментийг сайжруулах, дундын хоршоо байгуулах, туршлага судлах бүсчилсэн сургалт, үзүүлэх сургуулийг ОУ-ын төсөл хөтөлбөрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах

5.3.6. Хоршооны чиглэлээр зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх

5.3.7. Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлж хоршоо болох сонирхолтой байгаа нөхөрлөл, бүлгүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж хоршоо болгох ажлыг зохион байгуулах

5.4. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах нэгдсэн сүлжээ, үйлчилгээг бий болгох, зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.4.1. Хоршоо, нөхөрлөл, малчны бүлэг, хөдөөгийн иргэдийн бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр болон хэрэглэгчдэд шууд нийлүүлэх үйл ажиллагааг дэмжих.

5.4.2. Хоршоодын үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан, эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг бодлогоор дэмжин "Нутгийн брэнд" бүтээгдэхүүн бий болгох замаар үйлдвэрлэл болон борлуулалтанд нь арга зүйн дэмжлэг үзүүлэх

5.4.3. Мэргэжлийн холбоод, ТББ, ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хоршоодын бүтээгдэхүүн борлуулалтын нэгдсэн сүлжээ, үйлчилгээний төв байгуулах.

5.4.4. Хоршоодын органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

6.1. Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг аймаг, сумын түвшинд зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, орон нутгийн төр захиргааны байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллага, холбоодууд, ТББ-ууд хамтран ажиллана. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө, аж ахуйн газар болон сумдын Засаг дарга нар тэргүүлэх үүрэгтэй оролцоно.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Улс, орон нутгийн төсөв

7.2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө

7.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө

7.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

7.5. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

7.6. ОУ-ын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламж, төсөл, хөтөлбөрүүд

7.7. Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

8.1. "Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийг 2017-2020 онуудад хэрэгжүүлнэ.

8.2. Төр засгийн бодлого, шийдвэрийн нэмэлт өөрчлөлтүүд, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ зэрэгтэй уялдуулан шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах буюу үргэлжлүүлэн хугацаа сунгаж хэрэгжүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.

Ес. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, үр дүн

	Шалгуур үзүүлэлт	Хугацаа		Хүрэх үр дүн
		2016	2020	
1	Үнэлгээнд хамрагдсан хоршооны тоо	0	182	Хоршооны зарчмаар ажиллаж байгаа хоршоо нэмэгдсэн байна. Жишиг хоршооны тоо 10-аас доошгүй бий болсон байна
2	Төсвийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авалтанд оролцсон хоршоодын тоо	4	20	Хоршоодын орлого нэмэгдэж үйл ажиллагаа нь өргөжсөн байна.
3	ЖДҮХСан болон СХСан, ХЭДСангаас олгосон хөнгөлөлттэй зээлэнд хоршоодод олгосон зээлийн эзлэх хувь	2,1%	8%	Хоршоодын үйл ажиллагаа өргөжиж зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдсэн байна.
4	Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамрагдсан хоршооны тоо	0	10	ЗБДаалтын сангийн үйлчилгээнд хамрагдаж хөнгөлөлттэй зээл хөтөлбөрт хамрагдсан байна.
5	Хоршоог дэмжих зөвлөх үйлчилгээ	0	1	Хоршооны чиглэлээр олон жил ажилласан ахмад боловсон хүчнүүдийг зөвлөхөөр ажиллуулж хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.
6	"Нутгийн брэнд" бүтээгдэхүүний тоо	0	19	Сум бүр брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.
7	Хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн борлуулалтын нэгдсэн төв	0	1	Хоршоодын бүтээгдэхүүний борлуулалтын нэгдсэн төвтэй болсон байна. Хоршоодын н борлуулалтын орлого нэмэгдэж чадавхижсан байна.
8	Дундын хоршооны тоо	0	1	- Хоршоо нөхөрлөлийн кластер шинээр 1-ээс доошгүйг бий болгосон байна. - Дундын хоршоо бий болж хоршоодын хамтын ажиллагаа сайжирсан байна.

9	Үйлдвэрт нийлүүлсэн түүхий эд бүтээгдэхүүний хэмжээ	52 хоршо о 1450 тн	2 дахи н	Боловсруулах үйлдвэрт түүхий эд бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааг хоршоодоор гүйцэтгүүлж дэмжсэн байна.
---	---	-----------------------------	----------------	--

Арав . Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ

11.1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89-р тогтоолын 7.6.4 –т заасны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг заасан хугацаанд холбогдох газруудад хүргүүлнэ.

--oOo--